



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 6/14

Жавхлант

Мөнхчулууны Шаравгавааг
шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2024 оны 02 дугаар сарын 28-ны 82 дугаар тогтоолын хавсралт "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Захиргаа хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнээр ажиллаж байсан Мөнхчулууны Шаравгавааг 2025 оны 04 дугаар сарын 04-ны өдрөөс Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэнээр шилжүүлэн томилсугай.

2. М.Шаравгаваагын цалинг ТЗ-9 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалинг 1 283 000 (нэг сая хоёр зуун наян гурван мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 2 хувиар, орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар тус тус тооцон олгохыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг М.Шаравгаваад үүрэг болгосугай.

4. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Комиссын дарга : Э.Хонгорзул Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: П.Эрдэнэчимэг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Г.Батсайхан Нярав

5. Ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлж, холбогдох эд хөрөнгийг бүртгэлжүүлэн авахыг комиссын бүрэлдэхүүн (Э.Хонгорзул)-д даалгасугай.

ДАРГА



Р.ОЮУНЧИМЭГ